

**МОНГОЛ, ОРОС, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР
БАЙГУУЛАХ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС, БҮГД НАЙРАМДАХ
ХЯТАД АРД УЛС ХООРООНДЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН
САНАМЖ БИЧИГ**

Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс цаашид “Талууд” гэх,

2014 оны 9 дүгээр сард Душанбе хотноо болсон Талуудын төрийн тэргүүн нарын уулзалтаар хүрсэн нэгдсэн ойлголцлын үндсэн дээр дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

Нэг. Талууд гурван талын хил дамнасан тээврийг хөнгөвчлөх, худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг хангах, санхүү, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, улмаар бус нутгийн эдийн засгийн интеграцийг өргөжүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлт болон хамтын хөгжлийг бодитойгоор хангах зорилгоор “Талын зам”, “Торгоны замын эдийн засгийн бус” санаачилга болон Евразийн эдийн засгийн холбоог уялдуулж, Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулахаар тохиролцов.

Хоёр. Талууд “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг хамтран боловсруулахаар тогтов.

Гурав. Талууд “Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд хамрагдах өөрийн улсын бус нутгийн хүрээг бие даан тодорхойлно.

Талууд “Хөтөлбөр”-т гурван талын хамтын ажиллагааны дараах чиглэлүүдийг тусгахаар тохиролцов:

- 1) зам тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, харилцан холбогдох;
- 2) худалдаа, тээврийн нөхцөлийг сайжруулах;
- 3) хилийн боомтын бүтээн байгуулалт;
- 4) гаалийн хяналтыг сайжруулах;
- 5) санхүү, хөрөнгө оруулалт;
- 6) эрчим хүч;
- 7) хөдөө аж ахуй;
- 8) аялал жуулчлал;

- 9) хүмүүнлэгийн солилцоо;
- 10) экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах.

“Хөтөлбөр”-ийг боловсруулах болон хэрэгжүүлэх явцад харилцан сонирхсон хамтын ажиллагааны бусад чиглэлийг Талуудын тохиролцсоноор тусгаж болно.

“Хөтөлбөр” 5 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд Талууд өөрөөр тохиролцоогүй бол тав таван жилийн хугацаагаар аяндаа сунгагдана.

Талууд “Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх механизм байгуулна.

Дөрөв. “Хөтөлбөр” боловсруулах ажлыг 2015 онд багтаан дуусгах үүднээс энэхүү Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурснаас хойш 2 сарын дотор Талууд “Хөтөлбөр” боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг хариуцах байгууллагыг томилох бөгөөд эдгээр байгууллага нь “Хөтөлбөр” боловсруулах хамтарсан ажлын хэсэг байгуулж, анхдугаар хурлыг нь зохион байгуулан цаашдын ажлын дараалал болон хуваарийг тохиролцоно.

Талуудын Гадаад хэргийн яамд “Хөтөлбөр” боловсруулах хамтарсан ажлын хэсэг хооронд холбоо барих ажлыг хариуцна.

Тав. Хамтарсан ажлын хэсгийн хурлыг тохиролцсон давтамжтайгаар Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад ээлжлэн зохион байгуулна. Талууд харилцан тохиролцсоноор ээлжит бус хурал зохион байгуулж болно.

Зургаа. Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Талууд Харилцан тохиролцсоноор энэхүү харилцан ойлголцлын санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийг Уфа хотноо 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр монгол, орос, хятад хэлээр тус бүр 3 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ



БНХАУ-ЫГ
ТӨЛӨӨЛЖ



ОХУ-ЫГ
ТӨЛӨӨЛЖ

